**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 23 өдөр Дугаар А/320 Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын болон сонгодог урлагийн охийг орон нутгийн иргэдэд хүргэх, олон угсаатны өв, соёлыг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулахын зэрэгцээ "Хөөмийн концерт" бие даасан уран бүтээлийн тоглолтоо нутгийн зон олондоо толилуулж буй Хөгжимт драмын театрын хөөмийчин Х.Ганзоригийг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2.Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Х.Ганзоригт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг аймгийн Хөгжимт драмын театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Ариунжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

02-01561 D/Zax-A/320-Da